



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/290

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Цагаангууд овогтой Сампилын Ганбаатар (СЮ62101675)-ын эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг (Сариг), Пунцаг гудамж Б-43 тоотод байршилтай үйлчилгээний зориулалттай 4114м² газрыг “Тотал дистрибьюшин” ХХК (5167647)-д 40 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. “Тотал дистрибьюшин” ХХК-ий эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг “Тотал дистрибьюшин” ХХК-ий захирал (Б.Очирбат)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/233 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



231711811